

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, "УСДУ" ОНӨААТҮГ-ын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 195 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "УСДУ" ОНӨААТҮГ (Ш.Чинболд)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 154 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		төг/м ³	3,763.0
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	төг/ГЖ	43,941.0
		Тогтмол	төг/м ³	2,592.0
3	Төсөвт байгууллагын хэрэгцээний ус халаасан дулаан		төг/м ³	7,168.0

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		төг/м³	2,541.0	
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	төг/ГЖ	29,670.0	
		Тогтмол	төг/м³	1,750.0	
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээний ус халаасан дулаан		төг/м³	7,168.0	
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, “00”-ын өрөөний халаалт хамаарна)		төг/м²	1,120.0	
5	Орон сууцны халаалт	Хувьсах	төг/ГЖ	13,496.0	
		Тогтмол	төг/м³	760.0	
6	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор		Төг/хүн	5,600.0
		Усны зарцуулалтаар		төг/м³	2,800.0
		Хэмжүүрээр	Хувьсах	Төг/ГЖ	26,973.0
			Тогтмол	төг/м³	1,591.0
7	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м2 хүртэлх талбайтай айл өрх		төг/сар	4,200.0
		41 м2-ээс 80 м2 хүртэлх талбайтай айл өрх		төг/сар	7,000.0
		81 м2-ээс дээш талбайтай айл өрх		төг/сар	14,000.0